

ТҮРЭЭСИЙН ГЭРЭЭ

2023 оны 11 сарын 20 өдөр

№ 2023/106

Улаанбаатар хот

Нэг талаас “Эвсэг хөрш 90” СӨХ /цаашид түрээслүүлэгч гэх/ -ийг төлөөлж М.Сонинбаяр, нөгөө талаас Улсын бүртгэлийн РД:6021646 дугаартай Амгалан дулааны станц ТӨХК /цаашид түрээслэгч гэх/ -ийг төлөөлж Аж ахуй, хангамжийн хэлтсийн дарга Г.Баттулга нар Иргэний хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг үндэслэн харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Түрээслүүлэгч нь нэг автомашины дулаан зогсоолыг түрээслэгчид ашиглуулах, түрээслэгч нь энэхүү гэрээнд дурьдсан нөхцөлөөр дулаан зогсоолыг ашиглах, төлбөрийг төлөх харилцааг зохицуулна.

Хоёр. Гэрээний хугацаа

2.1. Энэхүү гэрээг талууд харилцан тохиролцож гарын үсэг зурж, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болох бөгөөд дулаан зогсоолыг 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл буюу 5 сарын хугацаатай ашиглахаар байгуулав.

-Түрээслэгчийн машины дугаар 11-99 УНС суудлын автомашин

Гурав. Гэрээний төлбөр тооцоо

3.1. Түрээслүүлэгчийн дулаан зогсоолын 5 сарын түрээсийн төлбөр 2650000 /хоёр сая зургаан зуун тавин мянга/ төгрөг болно.

3.2. Түрээслэгч түрээсийн төлбөрийг Хаан банкин дахь 5059130026 тоот дансанд шилжүүлж төлбөрийн баримт авна.

3.4. Гэрээг дуусгавар болтол гэрээ болон төлбөрийн баримтыг үрэгдүүлэхгүй байна.

Дөрөв. Талуудын эрх, үүрэг, хариуцлага

4.1. Түрээслүүлэгч нь цэвэр цэмцгэр, дулаан орчныг бүрдүүлж техникийн аюулгүй байдлыг бүрэн хангаж өгнө.

4.2. Байгалийн болон гэнэтийн давагдашгүй хүчин зүйлийн гэх мэт түрээслүүлэгчээс үл хамаарах шалтгаанаар тээврийн хэрэгсэлд хохирол гарвал түрээслүүлэгч нь төлбөрийн хариуцлага хүлээхгүй.

4.3. Гэрээнд заасан хугацаанаас өмнө гэрээг цуцалбал тавиагүй хоногийн төлбөрийн дүнгийн 15%-ийг суутган тооцно.

4.4. Түрээслэгч тээврийн хэрэгслийн байрлах талбайд машинаа тавиагүй үеийн хоногийг нөхөн тавиулахгүй. Түрээслэгч тээврийн хэрэгслийн байрлалд өөр хэрэгсэл тавиулах бол урьдчилан мэдэгдэж тухайн тээврийн хэрэгслийн дугаарыг харуул хамгаалалтын ажилтанд тэмдэглэл хийлгэсэн байна.

4.5. Түрээслэгч харуул хамгаалалтын ажилтанд машины түлхүүрийг үлдээхгүй байх, машины түлхүүрийг үлдээснээс үүдэн гарах аливаа асуудлыг хариуцахгүй.





- 4.6. Тээврийн хэрэгслийн жолооч зогсоолд машин тавихдаа бусдын өмчид хохирол учруулсан бол 100% хариуцан төлбөрийг барагдуулж хохиролгүй болгоно.
- 4.7. Зогсоолд машинаа угаах, засвар үйлчилгээ хийхийг хориглоно. Зайлшгүй хийх шаардлага гарвал урьдчилж зөвшөөрөл аван, кассанд төлбөрөө тушаасны дараа хийнэ.
- 4.8. Түрээслэгч нь гэрээний төлбөрөө төлөөгүй бол гэрээг цуцлах, машины улсын дугаарыг хурааж авах арга хэмжээ авах ба төлбөрөө төлсний дараа зогсоолоос гаргана.
- 4.9. Түрээслэгч нь машинаа тээврийн хэрэгслийн даатгалд даатгуулсан байх шаардлагатай.
- 4.10. Түрээслүүлэгч нь түрээслэгчийн тээврийн хэрэгслийн зогсоолд байх хугацаанд аюулгүй байдал, бүрэн бүтэн байдлыг хариуцна.
- 4.11. Зогсоолд байх хугацаанд түрээслэгчийн тээврийн хэрэгсэлд хохирол учирвал хохирлыг 100% төлж барагдуулна.
- 4.12. Түрээслүүлэгч нь зогсоолд тээврийн хэрэгслийг байрлуулахад бүрэн бүтэн байдлыг шалган хүлээн авна.

Тав. Бусад

- 5.1. Гэрээний талаар талуудын хооронд үл ойлголцол үүсвэл харилцан бие биеэ хүндэтгэн эвийн журмаар шийдвэрлэх бөгөөд эс чадвал хуулийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.
- 5.2. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах бол талууд харилцан тохиролцож эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулсан нөхцөлд хүчин төгөлдөр болно.

Зургаа. Нэмэлт нөхцөл

Гэрээ байгуулсан талуудын төлөөлөл:

“АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
 М.МӨНХӨӨ
САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ
 О.УДВАЛ
АЖ АХУЙ, ХАНГАМЖИЙН ХЭЛТСИЙН ДАРГА
 Г.БАТТУЛГА
ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН
Г.САРУУЛ
АХММХ-ИЙН АВТО ИНЖЕНЕР
 Н.САЙНБИЛЭГ
Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг
8 дугаар хороо УС15-1-1
15-385 хэсэг 712 тоот
Утас:77111252, факс:77111253

ТҮРЭЭСЛҮҮЛЭГЧ ТАЛ:

М.СОНИНБАЯР



Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг
14 дүгээр хороо Цагаанхуарангийн
90А байр 132 тоот
Утас:99034841